



**USAID**  
FROM THE AMERICAN PEOPLE



Economic Policy Reform and  
Competitiveness Project

# ЭЗБШӨЧ ТӨСЛИЙН САР ТУТМЫН ЦУВРАЛ

2008 оны 12 дугаар сар, 2009 оны 1 дүгээр сар

## Төр хувийн хэвшлийн түншлэлийг амжилттай хэрэгжүүлсэн олон улсын туршлагаас танилцууллаа

Замын-Үүдэд байгуулах гэж буй Логистикийн Паркад хувь оруулагчдыг дэд бүтцийн төслүүдэд төр хувийн хэвшлийн түншлэлийг амжилттай хэрэгжүүлсэн арга туршлагатай танилцуулах зорилгоор ЭЗБШӨЧ төсөл олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжилтэн Патрицио Мансиллаг Монголд урьж ажиллуулав.



Ноён Мансилла, Замын-Үүдэд Логистикийн Парк байгуулах ажилд оролцож буй тээвэр зуучлалын үйлчилгээ эрхлэгчдэд зориулан 2009 оны 1 дүгээр сарын 16-нд сургалт хийж дараахь асуудлуудыг хөндөн ярилцлаа. Үүнд:

- Үзэл баримтлалын, эрх зүйн болон бусад зохицуулалтын асуудлууд,
- Эдийн засгийн хувьд гаргасан зардлаа дөнгөж нөхөж байгаа боловч хөгжлийн хувьд чухал ач холбогдолтой дэд бүтцийн төслүүд дэхь Төр хувийн хэвшлийн түншлэлд хувийн хэвшлээс оруулах хөрөнгө оруулалтын эрсдлийг бууруулахад чиглэсэн шинэлэг нэгжийн жишээнүүд,
- Орлогын дундаж түвшин бүхий орнуудад дэд бүтцийн төслүүдийг санхүүжүүлж хэрэгжүүлэхэд амжилтаанд хүрсэн Төр хувийн хэвшлийн түншлэлийн кэйс судалгаа, сургамжууд,
- Замын-Үүдэд Логистикийн Парк байгуулахад гадаадын тэргүүний арга туршлага, зөвлөмжийг хэрэглэх тухай,

2009 оны 1 дүгээр сарын 19-нд хуралдсан УИХ-ын Төр хувийн хэвшлийн түншлэлийн асуудлаархи тусгай хорооны хуралдаан дээр хийсэн танилцуулгад дараахь асуудлуудад голлон анхаарал хандуулсан байна. Үүнд:

- Засгийн газар уламжлал ёсоороо эрхэлсээр ирсэн дэд бүтцийн эд хөрөнгө бүрдүүлэх, үйлчилгээ үзүүлэх

зэрэг ажил үүргийг хийж гүйцэтгэхэд хувийн хэвшлийн зүгээс оролцох оролцооны хэлбэрүүд,

- Хууль эрх зүйн хүрээ, ялангуяа ажил үйлчилгээний эрх буюу концесс олгосон гэрээнүүдтэй холбоотой асуудлууд,
- Латин Америкийн дундаж түвшний орлоготой орнуудад Төр хувийн хэвшлийн түншлэлийн бүтцийг бий болгох, хяналт тавихад ашиглаж байсан зохицуулалтын орчин ба төрөл бүрийн бүтцийг төлөвлөх, зохион байгуулах асуудал,
- Төр хувийн хэвшлийн түншлэлийн тэргүүлэх төслүүдийг онцгойлон авч үзэхэд нь тус дэм болох зорилгоор мэргэжлийн өндөр түвшний ажилтан, ажилчдыг элсүүлэх, сургах, тогтвортой ажиллуулах чиглэлээр тухайн орны нөхцөлд зохицсон төлөвлөлт, зохион байгуулалтын арга хэмжээ авах хэрэгцээ шаардлагууд. Түүнчлэн, олон улсын тэргүүний дэвшилтэт аргачлалын дагуу тендер зарлан шалгаруулж, үйл ажиллагаанд нь хяналт тавих тухай.



Дэд бүтцийн эд хөрөнгө бүрдүүлэх, үйлчилгээ үзүүлэх ажилд хувийн салбарын хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх өргөн хүрээтэй загваруудыг танилцуулан хэлэлцүүлсний дотор:

- Үйл ажиллагаа, удирдлагын менежментийн гэрээнүүд
- Лизинг
- Үйлчилгээний гэрээнүүд
- Эд хөрөнгөө хэсэгчлэн арилжих
- Барьж босго, Үйл ажиллагаа явуул, Дамжуул /БҮД/
- Зохион бүтээ, Барьж босго, Үйл ажиллагаа явуул, Дамжуул /ЗБҮД/
- Зохион бүтээ, Барьж босго, Санхүүжүүл, Үйл ажиллагаа явуул, Дамжуул /ЗБСҮД/
- Барьж босго, Үйл ажиллагаа явуула, Эзэмш /БҮЭЗ/ оржээ.

Энэхүү цувралд нийтлэгдсэн санаа бодол нь АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг болон АНУ-ын Засгийн газрын байр суурийг заавал илэрхийлсэн байх албагүй болно.

## ТХХТ-ийн загварууд



Манай орны хувьд хөгжиж буй орнууд дахь төр хувийн хэвшлийн түншлэлийн загваруудтай танилцаж, тодорхой ойлголт мэдлэг олж авах, тэдний алдаа оноон дээр суралцах нь ТХХТ-ийг амьдралд амжилттай хэрэгжүүлэхэд тохиромжтой эрх зүйн зохицуулалтын болон шаардлагатай бүтцийг бий болгоход тустай юм.

Монгол улсын засгийн газар нь төрөөс үзүүлж буй үйлчилгээнүүдийг цаашид улам өргөжүүлэн хөгжүүлэхэд хувийн салбарын идэвхтэй оролцоо, санхүүжилтийг татан оролцуулах нь төрийн өмчийн салбарын хүчин чадал, нөөц бололцоон дээр ихээхэн нэмэр болох юм. Ингэснээр гадаадын хөрөнгө оруулалтыг татах, ажил эрхлэлтийг дээшлүүлэх, эдийн засгийн өсөлтөд түлхэц өгөх, Монголын ард иргэдийн амьдралыг дээшлүүлэх замаар эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад зохих хувь нэмрээ оруулах болно.

Тус төсөл цаашид төрийн болон хувийн салбарын оролцогчдод тэдний дараахь үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх болно. Үүнд:

- Хувийн хэвшлийнхний санал санаачилгын үндсэн дээр Ерөнхий сайдын 2008 оны 10 дугаар сарын 23-ны зөвлөмжийн дагуу байгуулах Замын-Үүдийн Логистикийн Паркийн үйл ажиллагаанд зориулж ТХХТ-ийн аль зохимжтой бүтцийг бий болгож хөгжүүлэх,
- Тус төслөөс гурван жилийн өмнө боловсруулахад нь тусласан хуулийн төсөлд санал болгосны дагуу олон улсын тэргүүний арга туршлагаудад үндэслэн ажил үйлчилгээний эрх олгох гэрээ буюу концесс байгуулах эрх зүйн орчин бүрдүүлэх, хөгжүүлэх,
- Төр хувийн хэвшлийн түншлэлд таатай эрх зүйн орчин бүрдүүлэх, хөгжүүлэх,
- Төр хувийн хэвшлийн хамтарсан үйлдвэрүүдэд мөрдөх ёстой гэрээний хэрэгжилтэнд хяналт тавих, шагнаж урамшуулах, тендер зарлах, эрэмбэ дарааг нь тогтооход шаардлагатай зохицуулалтын болон бүтцийн хүрээг бүрдүүлэх, хөгжүүлэх,
- Гадаадын бусад байгууллагуудтай түншлэн энэ салбар дахь Монголын мэргэжлийн шинжээчдийг сургаж бэлтгэх, тэдний ур чадварыг цаашид дээшлүүлэхэд туслас,

Тээвэр зуучлалын бизнес эрхлэгчдэд болон УИХ-ын тусгай хороонд хүргүүлсэн ТХХТ-ийн тухай Ноён Мансиллагийн илтгэлүүдийг [www.eprc-chemonics.biz](http://www.eprc-chemonics.biz) сайтаас үзэж болно.

## Зээлийн мэдээллийн төв ХХК хувь эзэмшигчдийнхээ анхны хурлаа хийлээ

Зээлийн мэдээллийн төв ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) компанийг албан ёсоор бүртгүүлэх ажлаа эцэслэж байх явцдаа, 2009 оны 1 дүгээр сарын 9-нд анхны хурлаа хийсэн байна. ТУЗ нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Зээлийн мэдээллийн товчооны үйл ажиллагаа эрхлэгчийг гадаадаас сонгон шалгаруулах тендер зохион байгуулахад Олон улсын санхүүгийн корпорацийн (ОУСК) туслалцааг авахаар шийдвэрлэлээ. Сонгон шалгаруултанд тэнцсэн ийм үйлчилгээ эрхлэгч нь Монголын Зээлийн мэдээллийн товчоог байгуулж 49 хувийг нь эзэмших ба үлдэх 51 хувийг нь Монголын хувийн салбарынхан эзэмших юм.

Түүнчлэн ТУЗ-ийн хурлаар, компанийн эхлэлийн шатны үйл ажиллагаанд хяналт тавьж ОУСК-тай ажиллах төслийн менежер ажилд авахаар шийдвэрлэсэн байна. Зээлийн мэдээллийн төвийн хүсэлтийн дагуу Эдийн засгийн бодлогын шинэтгэл өрсөлдөх чадвар төслийн зүгээс тус компанийн ТУЗ-ийн ажилд зөвлөгөө өгч байхаар боллоо.



Зээлийн мэдээллийн төвийн хувь эзэмшигчээр Зоос банк, Хас банк, Худалдаа хөгжлийн банк, Хаан банк, Монгол шуудан банк, Голомт банк, Капитал банк, Капитрон банк, Хадгаламжийн банк, Чингис хаан банк, Эрэл банк, Тээвэр хөгжлийн банк, Үндэсний хөрөнгө оруулалтын банк, Кредит банк, Анод банк зэрэг арилжааны 15 банк, Юнайтэд финанс, мөн Монголын банкируудын холбоо оролцохоор болсон байна. Эдгээр хувь эзэмшигчид 2008 оны 12 дугаар сард анхны хурлаа хийж 5 гишүүнтэй Төлөөлөн удирдах зөвлөлөө байгуулсан юм.

Үйл ажиллагаагаа эхэлсний дараа Зээлийн мэдээллийн төв нь арилжааны зээлийн мэдээлэл эрхэлдэг Монголын хамгийн анхны байгууллага болно. Арилжааны үйл ажиллагааны бүтцийг бий болгох талаар ОУСК-ийн үзүүлж буй туслалцаа, ЭЗБШӨЧ төслийн туслалцаатайгаар нэг жилийн өмнө боловсруулсан Арилжааны зээлийн мэдээллийн үйлчилгээний тухай хуулийн төслийг батлуулахаар Монголын банкируудын холбоо үүрэг хүлээсэн, хувь эзэмшигчид үйлчилгээнийхээ чанарт анхаарлаа төвлөрүүлэх хүсэл эрмэлзэл дүүрэн байгаа зэрэг нь ийм үйлчилгээг нэвтрүүлж хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлнэ.

# Замын-Үүдэд Логистикийн Парк байгуулах зорилгоор Засгийн газартай хамтарсан Төр ба хувийн хэвшлийн түншлэл хэлбэрийн компани байгуулахаар тээвэр зуучлалын компаниуд Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурлаа

2009 оны 1 дүгээр сарын 22-нд Засгийн газартай хамтарсан ТХХТ-д суурилсан Логистикийн Паркийн Корпораци байгуулах зорилгоор тээвэр зуучлалын 10 компани тохиролцож Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурлаа. Санамж бичигт *Туушин ХХК, СБ Логистикс ХХК, Монгол-Экспресс ХХК, Трансгэйт ХХК, ВЛС ХХК, "Азийн зам" ХХК, Глобал логистикс ХХК, ЛандЭкс ХХК, Эрин интернэйшнл ХХК, Материал ИмпЭкс ХХК* зэрэг компанийн захирлууд гарын үсэг зурсан байна.

Уг санамж бичиг нь *Тээвэр зуучлалын үйлчилгээ эрхлэгчдийн холбоо* болон тээвэр зуучлалын үйлчилгээ эрхлэгчдээс Замын-Үүдийн дамжин өнгөрүүлэх байгууламжийн хүчин чадлыг дээшлүүлэх хойшлуулшгүй шаардлагыг Ерөнхий сайдын дэргэдэх *Хөрөнгө оруулалтын орчин ба Хувийн хэвшлийн хөгжлийн асуудал эрхэлсэн зөвлөлдөх зөвлөлд танилцуулсны дагуу* гарсан Ерөнхий сайдын 2008 оны 10 дугаар сарын 23-ны зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын эхлэл юм.

- 4.4. ЛПК байгуулах тухай Нэгдсэн Санамж Бичигт дараах зарчмуудыг тусгана. Үүнд:
  - 4.4.1. Корпорацийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмууд байгуулахад хувийн хэвхэл хэвхэлээр зарин барилдах ба корпорацийн дүрвэйн шилд төрийн орлогоо 25 хувийг хэргээрүй байна.
  - 4.4.2. Төрийн эзэмшсэн хувь нь Логистикийн Паркыг олох газар боловч төрийн өмчийн тухайн газар дээр бай болсон тохиолдол, барилга, байгууламж, ус суваг болон илгээлтэй хэргээс болон бусад гэд бүтээгч бүртэй.
  - 4.4.3. Хувийн хэвшлийн эзэмшсэн хувь нь Логистикийн Паркыг бүтээн байгуулах ажлын эхлэл үе шаттай санхүүжилтийг хэрэглэж болно.
  - 4.4.4. Төрийн эзэмшсэн хувь болон олгосон гарын үсгийг тодорхойлохдоо ирээдүйн мөнгөн урсгалыг хэрэгжүүлэх аргыг олгохыг, 60 жилийн туршийн төсвийн өсөлтийн үүсгэж тооцоох замаар төсвөл.
  - 4.4.5. Төрийн төсвийн салбарын асуудлыг хэрэгжүүлэх төрийн захиргааны төв байгууллага буюу Зөв Тээвэр, Барилга Хөл Байгуулахын Яам хэрэгжүүлэх.
  - 4.4.6. УБТЗ-ыг Корпорацийн хувь нийлүүлэгчээр шалгал оролцуулах бөгөөд төрийн эзэмшсэн хувьд болно.

**5. Үйл ажиллагаа, үйлчилгээний өнгөрөөлт**

- 5.1. ЛПК-г төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмууд үндэслэн 25-аас дээшгүй хувийг төрийн, 75 хувийг хувийн хэвшлийн өрсөлдөөнтэй хөгжүүлэхэд хэрэгжүүлэхийг нэгдсэн хамтгаар байгуулах.
- 5.2. Харилцан Ойлголцлын Санамж Бичгийн хүчин төгөлдөр байхад.
- 5.3. Энэхүү ХХК-ыг нь төрийн байгууллага буюу хувийн хэвшлийн тээвэр зурч хамгаалахын Нэгдсэн Санамж Бичгийн салбарын нэгэн хэсэг боловч дахь хүчин төгөлдөр байно.



урьдчилсан техник эдийн засгийн үндэслэл дээр гаргасан уг зөвлөмжид, Засгийн газрын зүгээс газар түрээслэх эрхийг хувь болгон нийлүүлж, харин хувийн хэвшил нь хөрөнгө босгохоос гадна паркийг ажиллуулах боломжтойг зөвлөсөн юм. Тэрчлэн, санамж бичгийн дагуу тээвэр зуучлалын салбарын өмнөөс Засгийн газартай хэлэлцээр хийх үүрэгтэй ажлын хэсэг байгуулсан байна. Ажлын хэсэг нь таван компанийн төлөөллөөс бүрдсэн ба үүнд *"Туушин" ХХК-ийн орлогч захирал Д.Пүрэвчулуун, "СБ Логистикс" компанийн захирал Б.Соронзонбаатар, "Монгол-Экспресс" ХХК-ийн ерөнхий захирал Я.Эрхэмбаяр, "Эрин интернэйшнэл" ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Энхээ, "Трансгэйт" ХХК-ийн захирал Д. Энхээ* нар орж байна.

Ерөнхий сайдын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын дараагийн шат болгож ТХХТ-ийн компанийн бүтэц бий болгох тухай Харилцан ойлголцлын санамж бичгийн төслийг ажлын хэсгээс боловсруулаад байна. Тээвэр зуучлал эрхлэгчид болон Засгийн газрын хооронд байгуулах тэрхүү санамж бичгийн төсөл одоогоор хэлэлцүүлгийн шатандаа байгаа ажээ. Гарын үсэг зурсны дараа ЭЗБШӨЧ төслийн зүгээс тээвэр зуучлал эрхлэгчдэд болон Засгийн газарт дээрх компанийн бүтцийг бий болгох, биелүүлэх боломжтой зорилтын талаархи дүн шинжилгээ, эрэлт хэрэгцээний талаархи судлагаа хийхэд туслана.

## Компанийн удирдлагын үүрэг, хариуцлага сэдвээр сургалтын хөтөлбөр боловсруулахаар Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурлаа

ЭЗБШӨЧ төсөл Санхүү эдийн засгийн дээд сургуультай хамтран ажиллах тухай Харилцан ойлголцлын санамж бичигт 2008 оны 12 дугаар сарын 16-нд гарын үсэг зурлаа. Энэхүү санамж бичиг нь 2008 оны 10 дугаар сард *Монголын компанийн хамтын удирдлагын үүрэг, хариуцлага* сэдэвт чуулга уулзалтаар эхэлсэн ЭЗБШӨЧ төслийн ажлын нэг хэсэг нь бөгөөд уг асуудлаар олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шинжээч Демир Енерийн туслалцааг авч байна.

Санхүүгийн зохицуулах хороо /СЗХ/, Монголын хөрөнгийн бирж /МХБ/, Монголын худалдаа аж үйлдвэрийн танхим /МХАҮТ/, Монголын ажил олгогч эздийн холбоо /МАОЭХ/, банкууд оролцсон уг чуулга уулзалтаас компани удирдах арга барилд оршиж буй дутагдлыг арилгах талаар дараах арга хэмжээнүүдийг авахыг зөвлөмж болгосон юм. Үүнд: (а) Компанийн удирдлагын арга барилыг сайжруулахын тулд одоо байгаа бүтцийнх нь чадварыг дээшлүүлэх, (б) Захирлуудын хүлээсэн үүрэг, хариуцлагаа ойлгох чадварыг нь дээшлүүлэх, (в) Хувьцаа эзэмшигчийн эрхийн талаархи олон нийтийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх, олон нийтийг



Замын-Үүдэд ТХХТ-ийн хэлбэрээр Логистикийн Парк байгуулах боломжийн талаархи ЭЗБШӨЧ төслийн зөвлөмжийг мөрдлөг болгосон уг санамж бичиг нь хоёр талын хамтын ажиллагааны хүрээг тогтоосон байна. Төслөөс хийсэн

ил тод, шударга орчинтой хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалт хийх талаар мэдлэг, боловсролыг нь дээшлүүлэх зэрэг арга замыг зөвлөмж болгожээ.

Санамж бичиг нь:

1. Санхүү эдийн засгийн дээд сургууль дээр компанийн захирлуудад заах компанийн удирдлагын эрх, үүргийн талаархи сургалтын хөтөлбөр боловсруулах. Энэ хөтөлбөр нь туршилтын байх бөгөөд түүнийг өргөжүүлэн Монголын бусад их дээд сургуулиудад заахаар төлөвлөж байна,
2. Санхүү эдийн засгийн дээд сургуулийн сонгон шалгаруулж, ЭЗБШӨЧ төслийн баталсан сургагч багш нарт зориулсан сургагч- багш бэлтгэх бүрэн хэмжээний дамжааны хичээлийн хөтөлбөр боловсруулах
3. Холбогдох үйлдвэрүүдийн захирлуудад зориулан бүрэн хэмжээний дамжааны хичээлээ туршилтын журмаар заах зэрэг зорилготой юм.

Санамж бичигт Санхүү эдийн засгийн дээд сургууль болон ЭЗБШӨЧ төслийн хамтын ажиллагааны хугацааг зааж, доорхи сэдвүүдээр сургалтын нийт 12 загварыг хамтран боловсруулахаар дурьдсан байна: Үүнд:

- Компаниуд ба компанийн удирдлагын үүрэг, хариуцлага
- Компанийн удирдлагын асуудлаархи Монголын ба олон улсын хууль эрх зүйн болон бусад зохицуулалтын хамрах хүрээ
- Удирдах зөвлөл /захирлын зөвлөл/
- Хувьцаа эзэмшигчид ба хувьцаа эзэмшигчийн үйл ажиллагаа
- Гүйцэтгэх ба гүйцэтгэх бус нөхөн олговор
- Санхүүгийн хяналт, санхүүгийн аудитын шалгалт, шалгалтын үр дүнг мэдээлэх
- Компани өөр компанийн хувьцааг худалдан авах, хоорондоо нэгдэх, өмч хөрөнгө нэмж авах
- Эрсдлийн менежмент
- Компанийн удирдлагын асуудалд санхүүгийн байгууллагууд болон түвшин тогтоогч байгууллагуудын гүйцэтгэх роль
- Компанийн нийгмийн өмнө хүлээх хариуцлага
- Зөвлөлийн хороод, хурлын байгууллага
- Ногдол хувь /дивиденд/, хөрөнгө оруулалт ба санхүүгийн бодлого, стратеги

Уг 36 цагийн загвар хичээлийн хөтөлбөр нь дотоодын эрх зүйн болон бусад зохицуулалтын шаардлагуудтай нийцэж байгаа бөгөөд компанийн удирдлагын талаархи олон улсын шилдэг арга ажиллагаануудыг багтаасан байх юм. Үүнээс гадна Санхүү эдийн засгийн дээд сургуульд одоо ашиглаж буй дэлхийн шилдэг туршлагыг багтаасан сургалтын материалаар баяжуулна. ЭЗБШӨЧ төсөл нь Доктор Демир Енерийн туслалцаатайгаар Санхүү эдийн засгийн дээд сургууль болон тус төслийн хамтран сонгож авсан багш нарт зориулан сургагч-багш бэлтгэх бүрэн хэмжээний дамжааны хичээлийн хөтөлбөр хэрэгжүүлнэ. Уг хөтөлбөрийг Монголын компанийн захирлууд, гүйцэтгэх захирлуудад туршилтын журмаар заасны дараа Санхүү эдийн засгийн дээд сургууль нь бусад их дээд сургуулиудтай хамтран өргөжүүлэн дэлгэрүүлнэ.

Энэхүү санаачлага нь цаашид компанийн удирдлагын асуудлаар өөрийгөө санхүүжүүлэн үргэлжлүүлэх чадвартай сургалтын бүтэц бий болгох зорилготой юм. Энэ талын мэдлэг түгээн дэлгэрүүлж, компанийн хамтын удирдлагын шилдэг арга барилуудыг нэвтрүүлснээр компани хэмээх энэхүү

хамтын байгууллагын дотор ил тод байдал, ажлын тайлагнал, хариуцлага сайжирч, хувьцаа эзэмшигч бүртэй тэгш харилцах шударга ёс тогтсоноор санхүүгийн боломж нь өсөж, авилга хэзээ хахууль байх нөхцөл арилж, өрсөлдөх чадвар нь дээшилнэ.

## “Joomla!” Агуулгын удирдлагын системийн Монгол хувилбар” сэдэвт сургалт зохион байгуулав

Мэдээлэл Технологийн Үндэсний Паркт 2008 оны 12 дугаар сарын 24-нд болсон Joomla! Агуулгын Удирдлагын Систем (АУС) сэдэвт нэг өдрийн сургалтанд Засгийн газрын агентлагуудын 29 вэбмастер оролцлоо. Уг сургалтаар Joomla! –гийн хамгийн сүүлийн хувилбарыг (1.5.9 хувилбар) танилцуулж одоо хэрэглэгдэж буй Joomla! International Mongolia Edition 1.1 хувилбараас хэрхэн шилжүүлэх тухай заалаа.

Энэ технологийн анхны эх хувилбар болох Joomla! International Mongolia Edition 1.0 –г 2007 оны 12 дугаар сард ЭЗБШӨЧ төслийн туслалцаатайгаар Мэдээл, Харилцаа холбоо, Технологийн газар (МХХТГ) олон нийтэд ашиглах боломжийг нээсэн юм.



Одоо тус төслөөс Joomla! –гийн хамгийн сүүлийн хувилбар 1.5.9-ын Монгол хэлний багцыг гаргахаар ажиллаж байна. Энэхүү Монгол хэлний багц нь Монгол хэлийг багтаасан Олон улсын Юникод кодчлолын системийг бүрэн дэмжиж ажиллах болно.

Төр, засгийн газрын байгууллагуудын төсөв санхүүгийн хязгаарлагдмал байдал, ажилтнуудынх нь Англи хэлний түвшин зэргийг харгалзан үзэж МХХТГ нь ЭЗБШӨЧ төслийн туслалцаатайгаар Joomla! АУС-ийг дотооддоо өргөн дэлгэрүүлэхээр ажиллаж байгаа билээ. Одоогийн байдлаар Монголын 13500 вэбсайт Joomla! International Mongolia Edition болох хамгийн сүүлийн 1.5.9 хувилбарыг ашиглаж байгаа юм.

Энэхүү цуврал нь ЭЗБШӨЧ төслийн үйл ажиллагааны сар тутмын цахим хэвлэл юм. Та өөрийн санал бодол, манай цувралыг захиалах буюу захиалгаа цуцлах хүсэлтээ ЭЗБШӨЧ төслийн цуврал хариуцсан эрхлэгчид дараах хаягаар ирүүлнэ үү.  
И-мэйл [fbertoli@eprc-chemonics.biz](mailto:fbertoli@eprc-chemonics.biz), факс: (976-11) 32 78 25.